



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02-өдөр

Дугаар 548

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.2, 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Татварын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 820,726,333.15 (найман зуун хорин сая долоон зуун хорин зургаан мянга гурван зуун гучин гурван төгрөг арван таван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Н.Баттулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайландаа тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001492

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2021 оны 12 дугаар сарын 02-ны  
өдрийн ~~12~~ дугаар тогтоолын хавсралт

Татварын ерөнхий газрын балансаас "Үндэсний Дата төв" УТҮГ-ын балансад  
шилжүүлэн бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын нийт үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Цахилгаан хангамжийн дэд станцын өргөтгөл, их чадлын тог баригч	5/17/2021	ш	1	820,726,333.15	820,726,333.15	-	820,726,333.15
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			1 (нэг)	820,726,333.15 (найман зуун хорин сая долоон зуун хорин зургаан мянга гурван зуун гучин гурван төгрөг арван таван мөнгө)		820,726,333.15 (найман зуун хорин сая долоон зуун хорин зургаан мянга гурван зуун гучин гурван төгрөг арван таван мөнгө)	